

БАТЛАВ. СОЁЛЫН ЯАМНЫ
СОЁЛЫН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГА

..... Д. НАРАНЦЭЦЭГ

**Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛД НЭР ДЭВШИГДСЭН БҮТЭЭЛД
ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, САНАЛ ДҮГНЭЛТ ГАРГАХ УДИРДАМЖ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгох журам”-г удирдлага болгон шилдэг зохиол, бүтээл туурвиж Монголын утга зохиолын хөгжил, ард түмнээ соён гэгээрүүлэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан зохиолч, судлаач, орчуулагч нар болон Монголын уран зохиолыг гадаадад сурталчлахад тодорхой хувь нэмэр оруулсан гадаадын иргэнд Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгоно.

Хоёр. Бүтээлд тавигдах шаардлага

- 2.1. нэр дэвшигчийн сүүлийн 2 жилд шинээр хэвлүүлсэн бүтээл байх;
- 2.2. Монголын Зохиолчдын эвлэл, Шинжлэх Ухааны академийн Хэл, зохиолын хүрээлэн, их дээд сургуулийн эрдмийн зөвлөл зэрэг мэргэжлийн байгууллагын удирдах зөвлөлөөр хэлэлцүүлсэн байх;
- 2.3. бүтээл нь зохиогчийн эрхийн болон түүнд хамаарах аливаа эрхийн зөрчилгүй байх;
- 2.4. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний язгуур эрх ашигт харшлахгүй байх;
- 2.5. Хүчирхийлэл, садар самууныг илэрхийлсэн утга агуулгагүй байх.

Гурав. Материал хүлээн авах

- 3.1. Соёлын сайдын тушаалаар байгуулагдсан комиссын хуралдааны шийдвэрээр Д.Нацагдоржийн нэрэмжит шагналд материал авах тухай урилгыг Соёлын яам болон холбогдох байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд зарлана.
- 3.2. Д.Нацагдоржийн нэрэмжит шагналаар шагнуулахаар нэр дэвшиж буй зохиолч, судлаач, орчуулагч нь дараах материалыг комисст 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:
 - 3.2.1 бүтээлийн болон зохиогчийн товч танилцуулга;
 - 3.2.2 нэр дэвшиж буй бүтээлийн хэвлэмэл болон цахим хувилбар;
 - 3.2.3 Монголын Зохиолчдын эвлэл, холбоо, уран бүтээлийн байгууллагын хамт олноор хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, шийдвэр;
 - 3.2.4 нэр дэвшиж байгаа бүтээлийг мэргэжлийн болон эрдэм шинжилгээний зөвлөлд хэлэлцүүлсэн санал, дүгнэлт;
- 3.3. Комисс календарийн 30 хоногт багтаан хуралдан санал, дүгнэлтийг гарган, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

Дөрөв. Комиссын бүтэц, эрх үүрэг

- 4.1. Төрийн захиргааны байгууллага, зохиолчдын байгууллага, зохиолч, судлаач, шүүмжлэгч, эрдэмтдийн төлөөлөл оролцсон орон тооны бус комиссыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.
- 4.2. Комиссын үйл ажиллагааны хэлбэр хуралдаан байх ба журмын 2.4-т заасан дөрөвний гурваас доошгүй хувь нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хурал хүчинтэй, хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн саналаар дүгнэлт гарна.
- 4.3. Хуралдааныг комиссын дарга удирдана. Хуралдааны саналыг нууцаар хураах ба оролцсон бүх гишүүдийн гарын үсэг зурснаар комиссын дүгнэлтийг баталгаажуулан соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгох шийдвэр гаргана.
- 4.4. Комиссын гишүүн нь үүрэгт ажилд томилогдсон хугацаанд өөрийн бүтээлээр шалгаруулалтад оролцохыг хориглоно.
- 4.5. Комиссын нарийн бичгийн дарга нь нэр дэвшсэн уран бүтээлийн баримт бичгийн иж бүрдлийг нэгтгэн гишүүдэд танилцуулах, хурлын тэмдэглэлийг үнэн зөв хөтлөх, холбогдох материалуудын бүрэн гүйцэд байдлыг ханган ажиллах үүрэгтэй.

Тав. Шагналд нэр дэвшсэн бүтээлийг хэлэлцэх, шагнал олгох

- 5.1. Шагналыг Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 124 дүгээр тогтоолын 3.3-т заасны дагуу 3 хүртэлх зохиолч, яруу найрагч, орчуулагч, шүүмжлэгчдэд Их зохиолчийн мэндэлсэн өдрөөр олгоно.
- 5.2. Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал хүртэгсдийн бүртгэл мэдээлэл, судалгааг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хадгална.
- 5.3. Шилдэг бүтээлд нэр дэвшигч тогтоосон хугацаанд материал ирүүлээгүй, удирдамжийн 3.2-т заасан иж бүрдэл дутуу материал ирүүлсэн тохиолдолд комисс хүлээн авахгүй.

.....оОо.....